



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайшагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Р.ОТГОНБААТАР ТАНАА

2023.02.24 № 44
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр халуун усны барилгын дээврийг засаж үндсэн хөрөнгийн дансанд сайжруулалтаар хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсвөөс Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны 8.5 сая төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгож, авлагаар тайлагнасан ч барагдуулаагүй зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

0012021190

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилт, 86 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 97.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 61

№/127 0320

Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлээ.

Аудитаар төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 838,083.00 */найман зуун гучин найман мянга наян гурав/* төгрөгийн балансын урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т */Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гаргаан ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно/*, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлтгүй байхаар төлөвлөж, зарцуулах/* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т */хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/* заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т */Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн амч, хоронго олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно/*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчин олгосон 838,083.00 */найман зуун гучин найман мянга наян гурав/* төгрөгийг холбогдох албан тушаалтнаас нөхөн гаргуулж Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн **100080000955** дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Р.Огтонбаатар, нягтлан бодогч А.Цогзолмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордог, Утас: 70593113

0012050365


**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 66

01/1270320

Мандалговь

Зорчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлээ.

Аудитаар үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 231,436.00 /хоёр зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун гучин зургаан/ төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.6-д /бүх зардал/, 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу хөтлөх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч Р.Отгонбаатар, нягтлан бодогч А.Цогзолмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

АУДИТОР

Ж.УГТАХБАЯР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113


0012041559

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛГЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Тайланг хугаанаа: 2023.02.13

№	Ажил гүйцэтгэлийн ангил, дансны үлдэгдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	5	6	7	8	Шалгагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
А		3	4	5	6	7	8	9	10
1	Зардлын данстай холбоотой асуудал	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн зардлаас олгосон.	231,436.00	Хугацаатай албан шаардлага хүргүүлэх	Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Хугацаатай албан шаардлага хүргүүлэх	Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн	Дарга, Нягтлан бодогч	Р.Отгонбаатар, А.Цогзолмаа
2	Зардлын данстай холбоотой асуудал	Үр дүнгийн тайланд түлш халаалтын зардлыг дутуу тайлагнасан.	5,604,900.00	Аудитын явцад залруулах	Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Аудитын явцад залруулах	Аудитын явцад залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Р.Отгонбаатар, А.Цогзолмаа
3	Зардлын данстай холбоотой асуудал	Төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр, төсвөөс урамшуулал олгосон.	838,083.00	Төлбөрийн акт тогтоох	Хариуг албан бичгээр хүргүүлнэ	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох	Дарга, Нягтлан бодогч	Р.Отгонбаатар, А.Цогзолмаа
4	Балансын данстай холбоотой асуудал	Төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилтийг хийгээгүй.	4,923,420.00	Аудитын явцад залруулах	Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Аудитын явцад залруулах	Аудитын явцад залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Р.Отгонбаатар, А.Цогзолмаа

Балансын данстай холбоотой асуудал	Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлд төвлөрүүлсэн орлогыг тайлагнаагүй.	9,429,483.00	Аудитын явцад зарлуулах	Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Аудитын явцад зарлуулах	Аудитын явцад зарлуулсан	Дарга, Нягтлан бодогч	Р.Отгонбаатар, А.Цогзолмаа
5								
	Нийт дүн	21,027,322.00						


 АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.УГТАХБАЯР
 Х.НАРАНЦАЦРАЛ
 Р.МӨНХТОГТОХ

ДАРГА
 НИЯГТЛАН БОДОГЧ

Р.ОТГОНБААТАР
 А.ЦОГЗОЛМАА

